

## МОНГОЛЫН ИНТЕРНЭТ ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН СУДАЛГААНЫ ХӨГЖИЛ, ХАНДЛАГА

The development and tendency of the internet linguistics study in Mongolia

*Д.Боролзой*

**Товч агуулга:** Уг өгүүлэлд монгол хэл шинжлэлийн шинэ судлагдахуун болох интернэт хэл шинжлэлийн судалгаа Монголд болон бусад улс орнуудад хэрхэн хөгжиж ирсэн болоод цаашдын чиг хандлагын талаар өгүүлжээ. Интернэтийн хэлийг судлах ажил 1980-аад оны сүүл үеэс АНУ-д эрчимтэй хөгжиж эхэлсэн гэдэг. Харин Английн хэл шинжлэлч, профессор Дэвид Кристал “Интернэт хэл шинжлэл” (Internet linguistics) хэмээх судалгааны энэхүү шинэ чиглэлийг үүсгэжээ.

**Түлхүүр үгс:** Монгол хэл шинжлэл, интернэт хэл шинжлэл, хэл шинжлэлийн түүх

Эдүгээ интернэт хэмээх зүйл мэдээлэл авахаас гадна хүмүүс хоорондын харилцааны маш том талбар болжээ. Ийм учраас интернэтийн орчинд болоод байгаа хэлний хувьсал өөрчлөлтийг нийгэм хэл шинжлэл болоод сэтгэц хэл шинжлэлийн талаас нь голчлон судалдаг байна. Мөн энэ харилцааны орчинг судлах хангалттай хэрэглэгдэхүүн бий болсон тул хэл найруулга, үгийн сан, хэл зүй, зэв бичих зүй зэрэг олон талаас нь судлах боломжтой юм. Монголд 2010 оноос интернэт хэл шинжлэлийн чиглэлээр анхны өгүүлэл, илтгэлүүд гарч эхэлснээр энэ чиглэлийн дагнасан судалгаа хөгжиж эхэлжээ.

Монголчуудын өвөг хүннүүд анх өөрийн өргөн уудам нутгийн хөндлөн гулд хурдан морины хүчээр мэдээлэл түгээх, цуглуулах улаач, буухиа элч нарыг ашиглаж байсан түүхэн баримт бий. Нүүдэлчдийн бүтээн бий болгосон эл мэдээлэл түгээх сүлжээг Чингис хааны гуравдугаар хөвүүн, Их Монгол улсын хаан Өгөдэй улам хөгжүүлэн 1235 онд морин өртөө байгуулсан нь харилцаа холбооны томоохон дэвшил байжээ. Энэхүү морин өртөө нь зөвхөн Монгол орны дотор биш тухайн үеийн Монгол гүрний уудам нутаг дэвсгэрийг хамардаг байсан юм. Ийнхүү монголчууд дундад зууны үед хэнд ч дийлдэшгүй хүчирхэг их гүрэн байгуулсан шигээ мэдээлэл, харилцаа холбооны хурдаараа ч тэр үеийн улс орнуудаас хол түрүүлж байжээ. Өөрөөр хэлбэл дундад зууны “өртөө” хэмээх зүйл нь өнөө цагийн “интернэт”-ийн мэдээлэл солилцох хурдан шуурхай байх үүргийг гүйцэтгэж байжээ.

Дундад зууны энэхүү “интернэт”-ээр монголчууд өөр хоорондоо элчээр амнаас ам дамжуулан харилцаж байсан уламжлал бий. Энэ нь “элчээр дуун бариулах ёс” буюу очих захианы агуулгыг элчид цээжлүүлэн хүргэдэг байсан монголчуудын аман уламжлал юм. Үүнийг “Хэлэх үг элчийн аманд бий” хэмээн ярилцдаг. Ийнхүү бидний нүүдэлчин монголчууд арвин баялаг аман зохиолтой, аман болон бичгийн гайхамшигтай уламжлалтай ард түмэн билээ. Техник технологи өндөр хөгжсөн эдүгээ цагт ч гэсэн энэхүү аман уламжлалын онцлог өнгө төрх интернэт орчинд ч үргэлжилж монгол хэлийг хувьсан хөгжих үйл явцад нөлөөлөх нэгэн хүчин зүйл болж байгаа нь сонирхолтой.

Ийнхүү орчин үед монгол хэлээр дамжиж байгаа мэдээллийн их урсгал болоод хүмүүс хоорондын харилцааны томоохон хэсэг интернэт орчинд төвлөрөх болжээ. Интернэт хэмээх зүйл нь өнөө цагт мэдээлэл, харилцааны хүчтэй хэрэгсэл болохынхоо хувьд нийгмийн сэтгэл зүй, хүмүүсийн харилцаа, ялангуяа хэлэнд үзүүлэх нөлөө нь багагүй болжээ. Жилээр биш сар, өдрөөр өөрчлөгдөн хувьсаж байгаа энэхүү мэдээллийн технологийн хурд дунд эх монгол хэлэнд минь нөлөөлж байгаа нөлөө нь ч тун хурдтай байна.

Харин энэ талаарх судалгаа буюу орчин үеийн энэхүү давалгаанд монгол хэл хэрхэн өртөж, хөгжих болон эс хөгжихийн аль нь болж буйг нарийвчлан судалсан хэлний судалгаа хангалттай биш учраас интернэт орчин дахь монгол хэлний асуудлыг тогтолцоотой нэгтгэн судлах зайлшгүй шаардлагатай. Түүнчлэн интернэтийн монгол хэлэнд үзүүлж байгаа нөлөөг дутуу үнэлэн огт анхаарахгүй өнгөрч болохгүй бөгөөд шүүмжлэхээс илүүтэйгээр орчин цагийн монгол хэлний

хөгжил хувьсалд болж байгаа бодит нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрч монгол хэл шинжлэлийн судалгааны нэгэн чухал объект болгон анхааралтайгаар нарийвчлан судлах нь чухал байна.

Мэдээллийн энэ их урсгал мэдээж хэлээр дамжина. Монгол улсын төрийн албан ёсны хэл бол монгол хэл билээ. Монгол хэлээр дамжиж байгаа энэ их мэдээллийн урсгалд эх хэл маань ч тодорхой хэмжээгээр бохирдох, эвдрэх, бас нөгөө талаар өөрчлөгдөн хөгжих нэгэн хөрс суурь нь болж байна. Интернэт орчныг хянах боломж муутай бөгөөд тэр хэрээрээ монгол хэлэнд нөлөөлж байгаа нөлөө нь бас хяналтгүй, судалгаа багатай, чиг баримжаагүй байна гэж хэлж болох юм. Эндээс интернэтийн орчинд монгол хэл маань мөхөөд байна уу, хөгжөөд байна уу? гэдэг асуудал урган гарч байна. Мэдээж бүх зүйл хоёр талтай байдаг. Нэг талаар монгол хэлийг улам баялаг агуулгатай, хөгжил хөдөлгөөнтэй, найруулгын олон өнгө төрхтэй болгох талаасаа хөгжүүлж байгаа боловч нөгөө талаар монгол хэлийг эвдэх, бүх нийтэд буруу үлгэр дууриал болохын хувьд мөхөөх тал нь давамгайлах хандлагатай байгааг ч мөн хүлээн зөвшөөрөх ёстой. Ийнхүү монгол хэлний энэхүү хувьсал өөрчлөлт нь хэл шинжлэлийн судлагдахуун болохоос гадна олон нийтийн дунд байгаа интернэт нь монгол хэлийг “мөхөөж” байгаа эсвэл “хөгжүүлж” байгаагийн алин болох тухай асуултад эрдэм шинжилгээний үндэслэлтэй хариулт өгөх шаардлага байгаа нь интернэт хэл шинжлэлийн судалгааны нэгэн чухал зорилт болно.

Телевиз, радио, сонин сэтгүүл буюу хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь олон нийтийн эх хэлний боловсролд эергээр, бас сөргөөр хамгийн хүчтэй нөлөөлдөг. Харин интернэт бий болсноор хэвлэл мэдээллийн хэрэгслийн зарим нэг үүргийг вэб сайтууд, нийгмийн сүлжээнүүд хуваалцах болсон билээ. Энэ үүрэг бол мэдээлэл түгээх, дамжуулах буюу өөрөөр хэлбэл олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн гүйцэтгэж ирсэн яг тэр үүрэг юм. Мэдээллийн вэт сайтуудыг хэлбэрийн хувьд өөр боловч агуулгын хувьд сонинтой адилхан гэж үзэж болно. Харин нийгмийн сүлжээний сайтууд нь хэдий мэдээлэл түгээх хэдий ч илүү амьд, хөгжил хөдөлгөөн бүхий хэлний орчин тул хэлээр дамжиж буй энэхүү хүмүүс хоорондын харилцааны хэлийг судлах нь шинээр тулгарч буй судлагдахуун юм.

Ийнхүү судлаачид сонин сэтгүүл, радио телевизийн хэл найруулга, хэлний онцлогийг ярьж, мөн хангалттай судалсаар ирсэн байдаг. Зарим нэг судалгааг товчхон дурдвал, судлаач Э.Сонинтогос (Сонинтогос, 2011) Монголын телевизүүдийн жишээн дээр зар сурталчилгааны хэлний онцлогийг судалсан бол судлаач Б.Нацагдорж (Нацагдорж, 2008) телевизийн мэдээллийн хэлийг хэлний бодлогын хүрээнд франц хэлтэй зэрэгцүүлэн судалжээ. Мөн судлаач Д.Хонгорзул (Хонгорзул, 2004) сонины мэдээллийг үгийн сангийн талаас нь судалсан байна.

Харин дээрх мэдээллийн хэрэгслээс хамаагүй илүү хүртээмжтэй, олон хүнд хүрдэг, идэвхтэй, хүчтэй мэдээллийн хэрэгсэл нь сүүлийн үед интернэтийн орчин болсон учраас түүнд явагдаж буй хэлний асуудлыг судлах нь монгол хэл шинжлэлийн ухаанд шинэ тутам судлагдахуун болж байна. Интернэт хэмээх зүйл мэдээлэл авахаас гадна хүмүүс хоорондын харилцааны маш том талбар болсныг бид бэлхнээ мэдэх билээ. Ийм учраас интернэтийн орчинд болоод байгаа хэлний хувьсал өөрчлөлтийг нийгэм хэл шинжлэл болоод сэтгэц хэл шинжлэлийн талаас нь голчлон судалдаг байна. Мөн энэ харилцааны орчинг судлах хангалттай хэрэглэгдэхүүн бий болсон тул хэл найруулга, үгийн сан, хэл зүй, зөв бичих зүй зэрэг олон талаас нь судлах боломжтой билээ. Интернэт орчны хэлний судалгааг тоймлон ярихад ерөнхийд нь дараах хоёр хэсэгт хуваан авч үзэх нь зүйтэй болов уу. Энэ нь нэгдүгээрт “Дэлхийн интернэт хэл шинжлэлийн судалгааны тойм”, хоёрдугаарт “Монголын интернэт хэл шинжлэлийн судалгааны тойм” болно.

### **Нэг. Дэлхийн интернэт хэл шинжлэлийн судалгааны товч тойм**

“Интернэтийн хэл хэрэглээг судлах ажил 1980-аад оны сүүл үеэс АНУ-д эрчимтэй хөгжиж эхэлсэн. 1984 онд Наоми Барон “Харж хүлээн авдаг хэл” (Visual Language) гэх цахим сэтгүүлд “Компьютерт суурилсан харилцаа хэлний өөрчлөлтөд нөлөөлөх нь” гэх сэдвээр өгүүлэл нийтлүүлсэн нь энэ талаар гарсан судалгааны ажлын анхны бүтээл болох юм. 1990-ээд оны эхээр (СМС) computer mediated communication буюу компьютерт суурилсан харилцаа гэх нэр томъёо түгээмэл хэрэглэгдэх болж компьютерийн орчны харилцаа, түүний хэл хэрэглээг судлах ажил өрнөсөнтэй холбоотойгоор 1995 онд харилцаа холбооны томоохон цахим сэтгүүл болох

“Компьютерт суурилсан харилцаа” (Journal of Computer – Mediated Communication) хэмээх сэтгүүлийн анхны дугаар хэвлэгдсэн” (Энхмаа, 2015: 10) байна.

Харин Английн хэл шинжлэлч, профессор Дэвид Кристал “Интернэт хэл шинжлэл” (Internet linguistics) хэмээх судалгааны энэхүү шинэ чиглэлийг үүсгэсэн бөгөөд “Хэл ба интернэт” (David Crystal, 2001), “Интернэт хэл шинжлэл” (David Crystal, 2011), “Интернэтийн хэлний нэр томъёоны тайлбар толь” (David Crystal, 2004) зэрэг бүтээлүүдийг туурвижээ. Өмнө нь судлаачид хэлний стандарт алдагдаж интернэт хэлний ирээдүйд муугаар нөлөөлнө гэсэн бол Дэвид Кристал харин үүнийг хэл шинжлэлд гарсан хувьсгал гээд хэлний олон хувилбар бий болж, хүний бүтээлч сэтгэлгээг нэмэгдүүлнэ хэмээн интернэтийг сайшаажээ. Тэрбээр “интернэт нь хэл хэрэглээг нэг талаар асар ихээр өөрчлөхийн зэрэгцээ нөгөө талаар хөгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэж байна... ..ярианы хэл, бичгийн хэлний шинж чанарыг тус тус гарган үзүүлж интернэтийн хэл нь ярианы хэл, бичгийн хэлний шинжийг зарим талаар зэрэг хадгалсан байдаг ч өөрийн өвөрмөц онцлогтой байдаг учир түүний давуу тал, хэлний хөгжилд нөлөөлөх нөлөө өндөр болохыг өгүүлсэн. Тухайлбал интернэтийн харилцаа нь чөлөөтэй, албадлагын бус шинжтэй, харилцан идэвхтэй, заавал хэл зүйн болон бусад дүрэмд захирагдах албагүй, баялаг шинжтэй байдаг” (Энхмаа, 2015: 13) гэжээ.

Хамгийн түгээмэл хэл болохын хувьд англи хэлээр өрнөж буй цахим орчны хэлний хувьсал хөгжлийн асуудлаар судлаач Дэвид Кристалаас гадна Наоми Бэрон (Naomi S Baron, 2008), Сюзан Херринг (Computer mediated communication linguistics, Social and cross-cultural perspectives, 1996), Рой Петер Кларк (Roy Peter Clark, 2009), Шерри Төркл (Sherry Turkle, 1995) зэрэг маш олон судлаачид интернэт хэл шинжлэлийн судалгааг хөгжүүлжээ. “Өрнө дахины эрдэмтэд интернэт харилцааг доорх байдлаар өргөн хүрээнээс нарийсган авч үзэн судалж байна.

- Интернэт (Internet) – харилцааны өргөн хүрээтэй орчин, орон зай
- Компьютерт суурилсан харилцаа (СМС) – Интернэтийн орчинд компьютер болон бусад хэрэгслээр харилцах харилцаа
- Компьютерт суурилсан дискурс (СМД) – Интернэтийн орчинд цахим хэрэгслээр дамжин бичвэрийн тусламжтай явагдах харилцаа
- Компьютерт суурилсан харилцан яриа (СМСs) – Интернэтээр явагдах харилцан ярианд нийгэм, сэтгэл зүй, хэлшинжлэлийн үүднээс дүгнэлт хийх. Энэ яриа нь интернэтийн орчны шинж чанар, харилцааны хэлбэрээс хамаарна.
- Нэг цагт зэрэг харилцах эсвэл ижил бус цагт харилцах текстэн харилцаа (synchronous and asynchronous discourse)” (Энхмаа, 2015: 20).

Интернэт хэл шинжлэлийн дээрх судалгаануудыг анзаарахад ихэвчлэн цахим орчин дахь хүмүүсийн харилцааны текстэд дүн шинжилгээ хийсэн, гарч буй хувирал хөгжлийг нь нээн илрүүлсэн буюу хэлний талаас нь анхаарсан прагматик судалгаа байна. Энэ мэтчилэн интернэтийн орчны хэлний өнөөгийн хөгжлийн байдал нь цахим харилцаанд идэвхтэй оролцож байгаа улс орон болгоны л хэлэнд тохиолдож байгаа асуудал учраас өөр олон улс орнуудад энэ талаарх судалгаа өргөн цар хүрээтэй хийгджээ. Тухайлбал, Орос улсад л гэхэд энэ талаар сүүлийн хэдэн жил олон арван эрдэм шинжилгээний бүтээлийг туурвин гаргажээ. “Тэдгээр бүтээлд ихэнхдээ интернэтийн хэлний үйл ажиллагааны онцлог, интернэтээр ижилсэх байдал үүсэх, хувь хүний бодит бус ертөнцийг сүлжээгээр дамжуулан илтгэх арга, интернэт дэх хэлэхүйн үйл ажиллагааны явц зэргийн талаар судалсан. Орос улсын интернэтийн хэлний судалгаа нь ихэвчлэн онолын үүднээс интернэтийн харилцааг тайлбарлахад чиглэгдсэн бөгөөд өрнө дахины судалгааны байдлыг тайлбарлан, интернэт хэлшинжлэлийн нэр томъёо, ухагдахууныг орос хэл рүү орчуулан тайлбарлахад чиглэгдэж байна” (Энхмаа, 2015: 20). Интернэт хэл шинжлэлийн чиглэлээр Е.И.Горошко, Е.Н.Галичкина, М.С.Рыжков, Л.А.Шестаков, О.В.Лутовинова, Т.Н.Колокольцева, Б.Я.Шарифуллин, Е.Б.Штукарева зэрэг Оросын эрдэмтэд судалжээ. Мөн түүнчлэн интернэтийн хэлний талаарх судалгааханз үсэг хэрэглэдэг Япон, Хятад зэрэг улсуудад ч идэвхтэй өрнөж байгаа бөгөөдхэл бичигт нь нөлөөлж байгааг хүлээн зөвшөөрч судалсаар байна.

### **Хоёр. Монголын интернэт хэл шинжлэлийн**

### судалгааны товч тойм

Монгол хэлэнд өрнөөд байгаа энэ асуудлыг нэг хэсэг “блогийн хэл”, “интернэтийн хэл” гэх мэтээр муушаан ярих төдий л байлаа. Хэлийг бохирдуулж байгаа талаас нь шүүмжлэхээс биш шинжлэх ухаанчаар судлах талаар хараахан учир дутагдалтай байсан гэж хэлж болно. Гэвч техник технологийн дэвшил, хөгжлөөр дэлхий нийттэй үргэлж хөл нийлүүлэн алхаж байдгийн хувьд монголчуудын дунд цахим хэрэглээ нэвтэрсэн тэр үеэс л монгол хэлэнд тохиолдох болсон цахим орчны монгол хэлний хэрэглээний талаарх судалгаа бусад улс орнуудтай харьцуулахад хожуу ч гэлээ анхлан хийгдэж эхэлсэн байдаг. Энэ талаар доктор Б.Энхмаа “2011 онд ШУА-ийн ХЗХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Боролзой “Интернэт монгол хэлний аюулгүй байдалд нөлөөлөх нь” хэмээх эрдэм шинжилгээний өгүүлэл бичсэн нь энэ талаар хийгдсэн судалгааны ажлын эхлэл гэж үзэж болно. Тус өгүүлэлд интернэт хэрэглээний давуу тал болоод дутагдалтай талыг монгол хэлний аюулгүй байдалтай холбон тайлбарлаж, улмаар интернэтийн орчин дахь монгол хэлний асуудлыг судлах нь монгол хэлшинжлэлийн хувьд шинэлэг хандлага болохыг дурьдаад энэ талаар өөрийн ажиглалт судалгааг хийж, тодорхой дүгнэлтийг гаргасан байна. Тэрээр тус судалгаандаа интернэт гар утасны мессеж, цахим шуудан, чат, компьютерийн орчин, вэб сайтуудаар дамжин монгол хэлэнд нөлөөлж байгааг дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд: Гадаад хэл болон бичгийн нөлөө, гадаад үг үгийн санд нэвтэрч нөлөөлөх, үг зүйн талаар нөлөөлөх (намайг-нааг г.м.), хэл найруулгын талаас нөлөөлөх гэх мэтээр тус бүрд нь авч үзэж, тодорхой жишээ баримтуудыг харуулжээ” (Энхмаа, 2015: 28) хэмээн бичжээ. Зохиогч дээрх өгүүллийг 2011 онд бус 2010 онд “Хэл зохиол судлал” сэтгүүлд нийтлүүлсэн бөгөөд энэхүү өгүүллийн санаагаар анх “Хүрэлтогоот-2010” эрдэм шинжилгээний бага хуралд “Интернэтийн орчин дахь монгол хэлний байдал” (2010.10.30) сэдэвтэй илтгэл хэлэлцүүлж байсныг ташрамд дурдъя.

Харин “интернэт хэл шинжлэл” (internet linguistics) хэмээх хэлшинжлэлийн энэхүү шинэ чиглэлийн далбаан доор яг тухайлан судлаагүй боловч зарим нэг судлаачид цахим орчны монгол хэлэнд тохиолдоод байгаа энэхүү үзэгдэлд анхаарал хандуулж байсан байдаг. Тухайлбал, доктор О.Самбуудорж “Одоо үед бичиг үсэг хэрэглэж буй монгол хэлт ард түмний бичгийн хэлний шинэ маягийн соёлын холбооны бас нэг онцлог бол, латин үсэг хэрэглэн интернэтээр харилцах байдал нэлээд бий болсон байна. Гэхдээ тэдний хэн нь ч латин үсгийг уншин, латин үсгээр тодорхой зүйл бичиж чадах боловч, нэгдсэн дүрэм хараахан үгүй тул, өөр өөрийн бичгийн хэлний дүрмийг баримтлах, эсвэл Монгол улсын кирил үсгийн дүрмийг баримталж бичих байдал нэлээд ажиглагдаж байгаа болно” (Самбуудорж, 2005: 39) гэсэн байна.

Доктор Г.Гэрэлмаа “Хэрэглээний хэл шинжлэл” хэмээх нэгэн сэдэвт бүтээлийг 2012 онд хэвлүүлжээ. Уг бүтээлдээ интернэтийн хэлийг сүүлийн үед хэрэглээний хэл шинжлэлийн нэг тусгай салбар болгон үзэж байгааг дурдаад интернэтийн орчин дахь монгол хэлийг хэрэглэгчдийн байдлыг дараах хоёр бүлэгт хуваан үзжээ. Энэ нь нэгдүгээрт, монгол хэлээр мэдээлэл цацагчдын үг хэл, хоёрдугаарт, санал буюу *comment* (тайлбар, сэтгэгдэл) бичигчдийн үг хэл г.м. Нэгдүгээр бүлэгт багтагсдын хэл найруулгын алдаа хоёрдугаар бүлгийнхнээс харьцангуй боловсронгуй /зарим сайтыг эс тооцвол/ хэлний хэм хэмжээнд нийцүүлэн мэдээллээ тавьдаг. Харин хоёрдугаар бүлгийнхэн бол хэлний хэм хэмжээ гэдгийг гол төлөв мартагсад бөгөөд тэд өөрийн хэлж болох боломжтой бүх бүдүүлэг үг хэллэгийг ашиглахыг хичээдэг” (Гэрэлмаа, 2012: 117) гээд “интернэтийн хэл, хэрэглээний үүргээ гүйцэтгэж буй боловч хэлний хэм хэмжээнд нийцэхгүй эх хэлний ариун байдалд сөргөөр нөлөөлж болох тул сайт болон блог ажиллуулагчид /admin/ мэдээллээ хэлний хэм хэмжээнд нийцүүлэн үлгэр жишээ болохуйцаар хийх, санал бичигчдийн этгээд үг хэллэгтэй саналыг хүлээн авахгүй байх зохион байгуулалт хийвэл эерэг нөлөөтэй” (Гэрэлмаа, 2012: 118) хэмээн өөрийн саналыг дэвшүүлжээ.

Доктор Б.Энхмаа “Интернэтийн хэл шинжлэл” хэмээх нэгэн сэдэвт бүтээлийг 2015 онд хэвлүүлсэн байна. Уг бүтээл нь интернэт хэл шинжлэлийн судалгааны талаар Монголд анх удаа гарсан нэгэн сэдэвт бүтээл бөгөөд интернэтийн хэлийг голдуу нийгэм хэл шинжлэлийн буюу хэлний хэрэглээний талаас нь судалсан тухайгаа “...судлаачид интернетийг шинжлэх ухааны гайхамшигт нээлт гэхээсээ илүү нийгмийн үзэгдэл, нийгмийн харилцааны орчин гэж үздэг бөгөөд интернетийн орчны хэл хэрэглээтэй холбоотой асуудлыг нийгэм хэлшинжлэлийн ухаантай холбон

авч судалдаг. Өөрөөр хэлбэл интернетийг нийгмийн үзэгдэл болохын хувьд нийгэм хэлшинжлэлийн үүднээс авч үзэж болох ба, хүмүүсийн хоорондох харилцааны нарийн үйл явц учир сэтгэц хэлшинжлэлийн үүднээс ч судалж үздэг байна” (Энхмаа, 2015: 9) гэжээ. Тус бүтээл нь гурван бүлэгтэй бөгөөд нэгдүгээр бүлэгт интернэт хэл шинжлэлийн үүсэл хөгжлөөс эхлээд Англи, Орос, Хятад, Япон зэрэг улсын интернэтийн хэлний судалгааны өнөөгийн байдлыг тоймлон өгүүлэхийн хамт энэ талаарх үзэл баримтлал, онцлог шинжийн талаар дэлгэрэнгүй өгүүлжээ. Хоёрдугаар бүлэгтээ Монгол улсын интернэтийн хэлний онцлог болох олон нийтийн цахим харилцааны хэлбэрүүд, латин үсгийн хэрэглээ гэх мэтээр хэрэглээний талаас нь авч үзсэн бол гуравдугаар бүлэгт монгол хэл ба Монгол улсын интернэтийн хэлний өнөөгийн нөхцөл байдал, түүнд нөлөөлөх нийгмийн хүчин зүйлсүүдийн талаар жишээ баримт татан судалсан шинэхэн байгаа энэ чиглэлийн судалгааны даацтай бүтээл болжээ.

### Дүгнэлт

Нийгмийн шинжлэх ухааны салбарт хамаардаг томоохон судалгааны чиглэл бол хэл шинжлэл юм. Хүмүүний хэлийг судалдаг шинжлэх ухаан бий болсноос хойш олон олон үзэл баримтлал бий болон нарийсан хөгжсөөр иржээ. Хэл шинжлэл нь орчин үед “Онолын хэл шинжлэл” (Theoretical linguistics), “Тодорхойлох хэл шинжлэл” (Descriptive linguistics), “Хавсарга хэл шинжлэл” (Applied linguistics) гэсэн гурван чиглэлээр хөгжиж байна. Дэлхийн хэл шинжлэлд үүсэн бий болоод удаагүй байгаа нэгэн шинэхэн салбар болох “интернэт хэл шинжлэл” нь хавсарга хэл шинжлийн чиглэлд хамаардаг билээ.

Судлах шаардлагагүй, аль эсвэл байж болохгүй жижиг зүйл мэтээр хайхралгүй орхисоор ирсэн зүйлс монгол хэл шинжлэлд бий. Мөн хэлэнд тохиолдож байгаа гаж үзэгдэл болгоныг судлаачид анхааран үзэлгүй хаясаар ирсэн байдаг. Эдүгээ дэлхийн олон оронд интернэтийн хэл шинжлэлийн судалгааны төвшин мэдээж өндөр байна. Харин Монголд хийгдсэн энэ чиглэлийн судалгаа тооны хувьд цөөн, басхүү шинэ тутам хэвээр байгаа боловч тодорхой амжилтад хүрсэн гэж үзэж болохоор болжээ. Учир нь интернэт орчны хэлний асуудалд монгол хэл шинжээчид анхаарлаа нэгэнт хандуулж эхэлсэн бөгөөд энэ талаар эрдэм шинжилгээний өгүүлүүд цөөнгүй хэвлэгдэж, мөн нэгэн сэдэвт судалгааны бүтээл гарсны хамт дагнасан судлаачидтай ч болсон нь олзуурхууштай байна.

Аливаа хэл нь байнга хөгжин хувьсаж өөрчлөгдөж байдаг “амьд организм” билээ. Монгол хэл ч бас энэхүү хэлний хөгжлийн түүхэн үйл явцыг тойрч биш дайрч өнгөрсөөр өнөөг хүрлээ. Энэ үйл явц өнөөдөр ч өрнөж байна. Харин энэ үйл явц өрнөх нэгэн хөрс нь интернэт орчин болжээ. Ийнхүү монголд интернэтийн хэлний судалгаа амжилттай хөгжиж байна...

### НОМ ЗҮЙ

**Боролзой, Д.** 2010 /а/. Интернэтийн орчин дахь монгол хэлний байдал, *Хүрэлтогоот-2010 эрдэм шинжилгээний бага хурлын илтгэл*

**Боролзой, Д.** 2010 /б/. Интернэт монгол хэлний аюулгүй байдалд хэрхэн нөлөөлөх нь. *Хэл зохиол судлал*. Т-III(35), fasc. 27. Уб., х.82-88.

**Гэрэлмаа, Г.** 2012. *Хэрэглээний хэл шинжлэл*. Уб

Интернет-коммуникация как новая речевая формация. 2014. Москва., Издательство “Флинта”. стр. 324

**Нацагдорж, Б.** 2008. *Монгол болон Франц улсын телевизийн мэдээллийн хэлийг хэлний бодлогын хүрээнд зэрэгцүүлэн судлах нь*. Уб., (Хэл шинжлэлийн ухааны докторын зэрэг горилсон бүтээл)

**Самбуудорж, О.** 2005. *Тод монгол үсгийн бичгийн хэлний тойм*. Осака

**Сонинтогос, Э.** 2011. *Телевизийн зар сурталчилгааны хэлний онцлог*. Уб., (Хэл шинжлэлийн ухааны докторын зэрэг горилсон бүтээл)

**Хонгорзул, Д.** 2004. *Сонины мэдээллийн дискурсын үгийн санг регистрийн үүднээс зэрэгцүүлэн судлах нь*. Уб., (Хэл шинжлэлийн ухааны докторын зэрэг горилсон бүтээл)

**Энхмаа, Б.** 2015. *Интернэтийн хэл шинжлэл*, Уб

- Computer mediated communication linguistics, Social and cross-cultural perspectives.* 1996. Philadelphia
- David Crystal.** 2004. *Glossary of Textspeak and Netspeak.* Edinburgh University Press
- David Crystal.** 2011. *Internet Linguistics.* New York
- David Crystal.** 2001. *Language and the internet.* New York
- Naomi S Baron.** 2008. *Letters by phone or speech by other means: the linguistics of email.* Always on, Oxford University press
- Roy Peter Clark.** 2009. *From telegraph to Twitter: The language of the short form.* Poynter online
- SherryTurkle.** 1995. *Life on the screen: Identity in the Age of the Internet.* New York. Simon and Shulster

## SUMMARY

The development of the internet linguistics study in Mongolia and other countries, which are new objects in Mongolian linguistics, is written in this article. In addition, the studies of internet language have been developing in USA since late 1980s. The linguist Prof David Crystal emphasized that internet linguistics is new direction in and the linguistics. The study of the internet linguistics has been developing since 2010, the first articles and reports of the internet linguistics have been published in Mongolia.

Уг өгүүлэл “Хэрэглээний хэл шинжлэл” сэтгүүлийн /УБ 2016, Боть I(16)/  
105-113-р талд хэвлэгджээ.